ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/10 Баян-Овоо сум

Эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2025 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ы. 6.4.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй аж ахуйн материалын 9 нэр төрлийн 60 ширхэг 2,907,500 (хоёр сая есөн зуун долоон мянга таван зуу) төгрөг, бусад материалын 10 нэр төрлийн 64 ширхэг 2,493,800 (хоёр сая дөрвөн зуун ерэн гурван мянга найман зуу) төгрөг нийт 19 нэр төрлийн 124 ширхэг 5,401,300 (таван сая дөрвөн зуун нэг мянга гурван зуу) төгрөгийн балансын үнэтэй эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг аж ахуйн нярав (Т.Хэрлэнчимэг), нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д даалгасугай.

2. Эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Эргэлтийн хөрөнгийг данснаас хасах, анхан шатны бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг өмч хамгаалах зөвлөлийн дарга Г.Энхсувдад даалгасугай.

ЗАХИРАЛ Ч.БОЛОРМАА

2326010073